



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/99

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 60.1.13, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1, 2.1.4, 4.1, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 9 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн төв тойрсон хяналтын цэгүүдэд ажилласан алба хаагчдын хоолны материалын болон хяналтын цэгүүдэд хүргэж үйлчилсэн шатахууны зардалд 5.118.500 (Таван сая нэг зуун арван найман мянга таван зуу) төгрөг, сумын нутаг дэвсгэрт гарсан малын гоц халдварт шүлхий өвчний тархалт нэмэгдэж байгаатай холбогдуулан өвчнийг нэмж тархаахгүй байх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж Рэнчинлхүмбэ суманд 5.000.000 (Таван сая), Жаргалант суманд 3.000.000 (Гурван сая) төгрөгийг тус тус олгосугай.

2. Дээрх зардлын 13.118.500 (Арван гурван сая нэг зуун арван найман мянга таван зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, аймгийн Шуурхай штабын дарга (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН